



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ  
**АСУУЛГА**

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай 1,  
Төрийн ордон, Утас: 26-70-16, Факс: 32-70-16  
E-mail: [stategreathural@parliament.mn](mailto:stategreathural@parliament.mn)  
<http://www.parliament.mn>

2012. 12.05 № 46

Асуулга тавих тухай

Мэдээлэл, харилцаа холбооны дэвшил нь орчин үеийн нийгэм, эдийн засгийн хүрээнд гүнзгий нэвтэрч, иргэд, байгууллага, төрийн бүхий л үйл ажиллагааны салшгүй хэсэг болоод байна.


Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7.1.13, 33.1.22-т заасны дагуу УИХ-ын гишүүний бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын мэдээлэл, харилцаа холбооны салбарын зарим үзүүлэлт, өнөөгийн нөхцөл байдлын талаар дараах асуулгыг Монгол Улсын Ерөнхий сайд Танд хандан тавьж байна. Үүнд:

1. Үүрэн холбооны хэрэглээ, хүртээмж, хамрах хүрээний өнөөгийн байдал, олон улстай харьцуулахад ямар түвшинд байгаа талаар;
2. Хөдөлгөөнт болон суурин интернетийн үйлчилгээний үнэ тарифын өнөөгийн байдал, олон улстай харьцуулахад ямар түвшинд байгаа талаар;
3. Монгол Улсад үндэсний дотоод роумингийн үйлчилгээг нэвтрүүлэх боломж, хэрэгцээ, шаардлага, энэ чиглэлээр цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар;
4. Үүрэн холбооны үйлчилгээний нэг хэрэглэгчийн дундаж орлого (ARPU)-ийн түвшин, бүтэц, олон улстай харьцуулахад ямар түвшинд байгаа талаар болон хэрэглэгчийн төлбөрийн чадварт нийцэж байгаа эсэх;
5. Сүүлийн үед зах зээлд финтек шийдэл бүхий үйлчилгээ эрхлэгчдийн (lend.mn г.м) хүүгийн түвшин, холбогдох үйлчилгээний шимтгэл, хураамжийн өнөөгийн байдал, эдгээрийн зах зээл болон хэрэглэгчдэд үзүүлэх эерэг, сөрөг нөлөөллийн талаар;
6. Цахим мөнгөний (sandy г.м) талаар баримталж буй бодлого, зохицуулалтын орчны өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага, эдгээрийн банк санхүүгийн салбарт үзүүлэх эерэг болон сөрөг нөлөөллийн талаар (зээл олгох нөхцөлүүд, зээлийн хүү болон банк санхүүгийн үйлчилгээний хураамжийг бууруулах, харилцагчдын эрх ашгийг дээдлэх г.м чиглэлээр);
7. Монгол Улсын мэдээллийн аюулгүй байдлын өнөөгийн байдал, эрсдлийн түвшин, цаашид энэ чиглэлээр тавьж буй зорилт, хэрэгжүүлэхээр төлөвлөж буй үйл ажиллагааны талаар;
8. Интернет орчинд хүүхэд, гэр бүлийн эрхийг хамгаалах бодлого, зохицуулалтын өнөөгийн байдал, түүний хэрэгжилтийн талаар;

Асуулгын хариуг Улсын Их Хурлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3-т заасан хугацаанд бичгээр ирүүлж, улмаар Улсын Их Хурлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.4-т заасны дагуу Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэхийг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН



Б. БААТАРБИЛЭГ